



**РАДИО ТЕЛЕВИЗИЙН СҮЛЖЭЭ  
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Бэлгэдлийн загвар, тодорхойлолт,  
хэрэглэх заавар батлах тухай

“РТС” УТУГ-ын дүрмийн 6.3.11, 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн  
ТУШААХ нь :

1. “Радио телевизийн сүлжээ” УТУГ-ын бэлгэдлийн загвар, тодорхойлолт,  
хэрэглэх зааврыг хавсралтаар баталсугай.

ДАРГА



Ч.ОЮУНБААТАР



РТС УТҮГ-ын Даргын 2015 оны  
...-р сарын ...-ны өдрийн  
... тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**РАДИО ТЕЛЕВИЗИЙН СҮЛЖЭЭ УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН  
ГАЗРЫН БЭЛГЭДЛИЙН ЗАГВАР, ТОДОРХОЙЛОЛТ ХЭРЭГЛЭХ  
ЗААВАР**

Нэг: Бэлгэдлийн загвар



Хоёр: Бэлгэдлийн тодорхойлолт

1.1 Бэлгэдлийн гол хэсэгт "Радио Телевизийн Сүлжээ" УТҮГ-ын нэрний товчилсон "РТС" үсгүүд "Т"- үсэгний улаан өнгө нь антенн матчийг, "Р", "С" үсэгнүүд нь тэнгэрийн цахирал өнгийг болон радио долгионыг илэрхийлнэ. /Өнгөний код "Р" - #0f84db, "Т" - #000000, "С" - #0f84db, "РАДИО" - #0f84db, "ТЕЛЕВИЗИЙН" - #ff0000, "ҮНДЭСНИЙ" - #000000, "СҮЛЖЭЭ" - # 0f84db/

1.2 Бэлгэдлийн эллипс хэлбэрийн цацраг нь радио долгионы тархалтыг илэрхийлж өнгөтэйгөөр дүрслэгдэнэ. /Өнгөний код : #1e2188/

1.3 Бэлгэдлийн "РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" гэсэн үгний өндөр 0,8см, "Аrial MTT" фондоор бичигдсэн. "Т" үсэгний өндөр 7.1см, өргөн 8см "Р", "С" үсэгний өндөр 5.7см, өргөн 3.5 см бэлгэдлийн нийт өндөр 16см, өргөн нь 27.6см байна.

Гурав: Бэлгэдлийг хэрэглэх заавар

- 3.1 Бэлгэдлийг дараах байдлаар хэрэглэнэ.
  - 3.1.1 Байгууллагын хаяг, албан бланк, хуралдаан, уулзалтын танхим, ёслол хүндэтгэлийн зориулалт бүхий өрөө, албан тасалгаа.
  - 3.1.2 Байгууллагын онцлогийг харуулсан сургалт, сурталчилгаа, нээлттэй хаалганы өдөр, ойн өдөр, улс бүсийн болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж байгаа хурал, цуглаан зөвлөгөөн тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үед тухайн арга хэмжээ болж байгаа танхим.
  - 3.1.3 Урилга, мэндчилгээ, ном, гарын авлага, зурагт хуудас, нэрийн хуудас, энгэрийн болон дурсгалын тэмдэг, үнэмлэх, цахим хуудас, тэмдэглэлийн дэвтэр, хуанли, урамшуулал, бэлэг дурсгалын зүйл, өргөмжлөл, цом, мэдээ материал, нийтлэл, тайлан, эмхтгэл, судалгааны материал.
- 3.2 Бэлгэдлийг өөр зорилгоор хэрэглэх, дуурайлган үйлдэх, гутаан доромжлох, эх загварыг санаатайгаар гуйвуулан өөрчлөх, дүрслэхийг хориглоно.